



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН  
ГАЗРЫН 2019 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2019.10.11

Улаанбаатар хот

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго:**

Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын үйл ажиллагаанд 2019 оны 3 дугаар улирлын байдлаар хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”, Зам, тээврийн сайдын 2017 оны 259 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Бодлого, төлөвлөлтийн газарт төлөвлөсөн болон хариуцан хэрэгжүүлэх 351 арга хэмжээний хэрэгжилт 3 дугаар улирлын байдлаар үнэлэгдэж байна. Эдгээрийн биелэлт нь дундаж дүнгээр 85.3 хувьтай байна. Үүнд:

| №          | Хяналтанд байх арга хэмжээ   | Нийт арга хэмжээ | Биелэлт /Хувиар/ |            |          |            |          |          |          |          |          | Хугацаа боловгүй | Үнэлэх боломжгүй | Хүчингүй болсон |
|------------|--|------------------|------------------|------------|----------|------------|----------|----------|----------|----------|----------|------------------|------------------|-----------------|
|            |  |                  | Дундаж хувь      | 100        | 90       | 70         | 50       | 40       | 30       | 10       | 0        |                  |                  |                 |
| 1          | Бодлого, төлөвлөлтийн газрын 2019 он гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт                                  | 73               | 84               | 43         | -        | 21         | -        | -        | 1        | -        | 4        | 4                | -                | -               |
| 2          | Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | 13               | 64.6             | 4          | -        | 4          | -        | 4        | -        | -        | 1        | -                | -                | -               |
| 3          | Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт                           | 1                | 40               | -          | -        | -          | -        | 1        | -        | -        | -        | -                | -                | -               |
| 4          | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт   | 110              | 90.7             | 67         | -        | 27         | -        | -        | 1        | -        | -        | 15               | -                | -               |
| 5          | Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт   | 54               | 83.6             | 25         | -        | 20         | -        | -        | 1        | -        | 1        | 2                | -                | 5               |
| 6          | Төрийн нарийн бичгийн дарга тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт                                  | 24               | 86.1             | 15         | -        | 6          | -        | -        | 2        | -        | -        | 1                | -                | -               |
| 7          | Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний биелэлт                                   | 26               | 84.8             | 14         | -        | 5          | -        | -        | 1        | -        | 1        | 5                | -                | -               |
| 8          | Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн биелэлт   | 6                | 88               | 3          | -        | 2          | -        | -        | -        | -        | -        | 1                | -                | -               |
| 9          | Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллийн нэгдсэн тайлан                                 | 17               | 85.9             | 9          | -        | 8          | -        | -        | -        | -        | -        | -                | -                | -               |
| 10         | Сайдын зөвлөлийн хуралдааны төлөвлөгөөний биелэлт  | 4                | 92.5             | 3          | -        | 1          | -        | -        | -        | -        | -        | -                | -                | -               |
| 11         | Сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрийн биелэлт   | 13               | 79.2             | 4          | -        | 9          | -        | -        | -        | -        | -        | -                | -                | -               |
| 12         | ЗТХС, нийслэлийн ЗД-тай байгуулсан санамж бичгийн биелэлт  | 10               | 83.8             | 5          | -        | 2          | -        | -        | 1        | -        | -        | 2                | -                | -               |
| <b>III</b> | <b>ДҮН</b>   | <b>351</b>       | <b>85.3</b>      | <b>192</b> | <b>-</b> | <b>105</b> | <b>-</b> | <b>5</b> | <b>7</b> | <b>-</b> | <b>7</b> | <b>30</b>        | <b>-</b>         | <b>5</b>        |



**Хоёр. Нийт арга хэмжээнүүдийн дэлгэрэнгүй танилцуулга:**

Төлөвлөсөн арга хэмжээг ангилал тус бүрээр авч үзвэл:

**2.1. Бодлого, төлөвлөлтийн газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3 дугаар улирлын хэрэгжилт:**

Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 73 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба гүйцэтгэл нь 3 дугаар улирлын байдлаар 84 хувийн хэрэгжилттэй үнэлэгдлээ.

| Улирал | Хяналтанд байх арга хэмжээ | 2019 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ | Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/ | Биелэлт /Хувиар/ |     |    |    |    |    |    | Хугацаа болоолгүй | Үнэлэх боломжгүй |   |
|--------|----------------------------|--------------------------------------|---|------------------|-----|----|----|----|----|----|-------------------|------------------|---|
|        |                            |                                      |   | Дундаж хувь      | 100 | 90 | 70 | 50 | 30 | 10 |                   |                  | 0 |
| III    | Гүйцэтгэлийн төлөвлөгөө    | 73                                   | 69  | 84               | 43  | -  | 21 | -  | 1  | -  | 4                 | 4                | - |

3 дугаар улирлын тайлангаар газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд 30 хувийн үнэлгээтэй 1 арга хэмжээг хэрэгжилт хангалтгүй, 4 арга хэмжээг хэрэгжээгүй гэж үнэллээ. Үүнд:

| № | Төлөвлөсөн арга хэмжээ   | Хэрэгжилт   | Үнэлгээ |
|---|--|---|---------|
| 1 | 1.1.6 “Монгол-Орос-Хятадын Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-т туссан төслүүдийг хэрэгжүүлэхтэй холбогдуулж ГХЯ болон бусад яамдтай хамтарч ажиллах /Улаанбаатар хотноо Хамтарсан хөрөнгө оруулалт, зураг төслийн төв байгуулах ажлыг эхлүүлэх/ 1-9 сар Б.Бадрал | Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.116.1.-т Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт тусгагдсан тээврийн салбарын төсөл, арга хэмжээг судалж хэрэгжүүлэх. Төсөл, арга хэмжээг нэг бүрчлэн судлах судалгааны ажлыг хийж дуусгах гэж заасны дагуу зам, тээврийн салбарын нийт 13 төслийн хэрэгжилтийн явцын мэдээллийг боловсруулж ГХЯ-ны Хөрөнгө оруулалтын судалгааны төвд хүргүүлсэн. Мөн тус төвд Хөтөлбөрт тусгагдсан зам, тээврийн салбарын төслийн хэрэгжилтэд шаардлагатай санхүүжилтийг олон улсын банк, санхүү болон эдийн засгийн бусад байгууллагатай хамтран шийдвэрлэх болон дэд бүтцийн төслүүдийн судалгааны ажлыг техникийн туслалцааны хүрээнд хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх саналыг өгсөн. “Монгол-Орос-Хятадын Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-т “Хөтөлбөрийг хэрэгжүүлэх механизм” хэсэгт Талууд техник эдийн засгийн үндэслэлийг бэлтгэх зорилгоор хөрөнгө оруулалтын зураг төслийн хамтарсан төвийг байгуулах боломжийг судалж, эдийн засгийн үндэслэлтэй тохиолдолд тус төвийг байгуулна... гэж заасан болно. Хятадын талын дэвшүүлсэн “Монгол-Орос-Хятадын Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийн төмөр замын төв коридорын хөгжил шинэчлэлийн техник эдийн засгийн үндэслэл судлах ажлын төлөвлөгөөний төсөлд санал боловсруулж ГХАХ-т өгсөн. | 30%     |
| 2 | 1.1.11 Алтанбулагт ложистикийн төв байгуулах /Урьдчилсан судалгаа хийгдсэн байна/-1-2 улирал /Хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр ажилласан байна/-3-4 улирал Т.Батцэцэг   | БХБЯ-ны захиалгаар хэрэгжүүлж байгаа Алтанбулаг боомтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах төслийн хэлэлцүүлэгт оролцон Алтанбулагт ложистикийн төв байгуулах саналыг тавьсан. Алтанбулаг ложистикийн төвийн санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор танилцуулга бэлдсэн. Үндэсний хөгжлийн газрын төслийн багийнханд 2020-2045 онд хэрэгжүүлэх төслийн жагсаалтад Алтанбулаг ложистикийн төвийг оруулахаар танилцуулгыг хүргүүлсэн.  | 0       |
| 3 | 1.1.12 Зам тээврийн салбарын инженерүүдийн улсын анхдугаар зөвлөгөөнийг зохион байгуулах /Улсын анхдугаар зөвлөгөөнийг зохион байгуулсан байна/  | Зам, тээврийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн зохион байгуулах бэлтгэлийг хангах ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулсан. Зам, тээврийн хөгжлийн яамны харьяа байгууллага бүр уг зөвлөгөөнийг зохион байгуулах Ажлын хэсэг байгуулан төлөвлөгөө, удирдамжийг батлан ажиллахыг үүрэг болгосон албан бичгийг Иргэний нисэхийн ерөнхий газар МИАТ ТӨХК, “Улаанбаатар төмөр зам” ХНН, “Монголын төмөр зам” ТӨХК, “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ, “Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ, Далайн захиргаанд хүргүүлсэн.   | 0       |



|   |  |  |   |
|---|--|--|---|
|   | 3, 4 дүгээр сард<br>М.Угтахбаяр  | Эдгээр газруудад холбогдох Ажлын хэсгүүд байгуулагдан зөвлөгөөн зохион байгуулах төлөвлөгөөг батлан ажиллаж байна. Зөвлөгөөний үеэр тавигдах илтгэлүүдийн сэдвийг боловсруулсан бөгөөд ШУТИС-аас тавих илтгэлийг ирүүлэх тухай 02/177 тоот албан бичгийг хүргүүлсэн. Ажлын хэсгийн даргын зүгээс зөвлөгөөний бэлтгэл ажлын тухай Сайдад танилцуулан холбогдох чиглэл авсны дараа зохион байгуулалтын арга хэмжээ авах чиглэл өгсөн.  |   |
| 4 | 3.1.1. Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулах /Хөтөлбөр батлагдсан байна/<br>3 улирал<br>Д.Бодьсайхан   | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах 249 дүгээр журмын хүрээнд Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулах олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахаар бэлтгэж байна.   | 0 |
| 5 | 4.4.6 Авто зам, автотээвэр, төмөр замын салбарт олгогдож байгаа гэрчилгээ, зөвшөөрөл олгох ажлыг цахимжуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах /Цахимжуулсан байна/<br>1-4 улирал<br>Д.Бодьсайхан | “Авто замын норм нормативын сан”-гийн хөрөнгөөр 2018-2019 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний дагуу “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 90, 142 дугаар тушаалаар батлагдсан тус сангийн журмыг хэрэгжүүлж, “Зам, тээврийн салбарын тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, гэрчилгээ, эрх олгох бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулах, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх програм хангамж” боловсруулах зөвлөх үйлчилгээний тендерийн зарлалыг 2019 оны 5 дугаар сарын 01-ний өдөр төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр олон нийтэд нээлттэй зарласан. Зарлалын дагуу зөвхөн 1 байгууллага чадварын мэдүүлгээ ирүүлсэн тул Зам, тээврийн хөгжлийн төвийн Захирлын 2019 оны А/29 (А/62 гишүүн чөлөөлж, нэмсэн) дугаар тушаалаар батлагдсан Үнэлгээний хороо “3 ба түүнээс дээш материал ирээгүй” үндэслэлээр тендер шалгаруулалтыг (дэлгэрэнгүй жагсаалтад мэдүүлэг ирүүлэх урилгыг 14 хоног) 2019 оны 5 дугаар сарын 27-ний өдөр дахин зарласан.<br>“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн хүрээнд Зөвлөх үйлчилгээний нээлттэй тендер шалгаруулалтын журмын дагуу зөвлөхийн дэлгэрэнгүй жагсаалт үүсгэсэн ба дэлгэрэнгүй жагсаалтад хүсэлтээ ирүүлсэн 3 байгууллагын мэдүүлгийг хянан үзэхэд Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн IV бүлгийн 14-16 дугаар заалтын шаардлагыг хангасан байсан тул 2019 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 1/505 тоот албан бичгээр дээрх байгууллагуудад саналын урилгыг хүргүүлсэн.<br>Энэхүү зөвлөх үйлчилгээний 2 дахь зарлалын тендерийн нээлтийг 2019 оны 8 дугаар сарын 08-ны өдөр нээн, тендерийн жишиг баримтад тусгагдсан шаардлагын дагуу нэр бүхий 2 байгууллагаас ирүүлсэн тендерүүдийг үнэлсэн боловч оролцогчидын техникийн саналын оноо хүрээгүй тул “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 36.18 дахь заалтад “Энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан зөвлөх сонгох тендер шалгаруулалт хоёр удаа амжилтгүй болсон тохиолдолд шууд гэрээ байгуулж болно.” гэж заасны дагуу Тендерийн жишиг баримт бичгийг дахин хянаж батлан зөвлөхийг хосолмол үнэлгээний аргын хялбаршуулсан хэлбэр болох бага үнийн аргаар шалгаруулахаар 2019 оны 9 дүгээр сарын 19-ны өдөр цахим системээр болон Өнөөдөр сонин дахин зарлаад байна. | 0 |

**2.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт:**

Тус газар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба хэрэгжилт 64.6 хувьтай байна.

| Улирал | Хяналтанд байх арга хэмжээ | 2019 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ | Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/ | Биелэлт /Хувиар/ |     |    |    | Үнэлэх боломжгүй |
|--------|----------------------------|--------------------------------------|---|------------------|-----|----|----|------------------|
|        |                            |                                      |   | Дундаж хувь      | 100 | 70 | 40 |                  |
|        |                            |                                      |   |                  |     |    |    |                  |



|     |  |    |    |      |   |   |   |   |   |
|-----|--|----|----|------|---|---|---|---|---|
| III | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт | 13 | 13 | 64.6 | 4 | 4 | 4 | 1 | - |
|-----|--|----|----|------|---|---|---|---|---|

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тус газрын хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний 2019 оны 3 дугаар улирлын хэрэгжилтэд 40 хувийн үнэлгээтэй дараах 4 арга хэмжээг хэрэгжилт хангалтгүй, 1 арга хэмжээг хэрэгжээгүй гэж үнэллээ. Үүнд:

| № | Арга хэмжээ   | Хэрэгжилт   |     |
|---|---|---|-----|
| 1 | 2.11.2. “Эдийн засгийн коридор” хөтөлбөрийн хүрээнд 3 улсын хил дамнасан олон улсын авто замын транзит тээвэрлэлтийн тодорхой хэсгийг Алтанбулаг чөлөөт бүсээр дамжин өнгөрүүлэх асуудлыг судлан шийдвэрлүүлэх<br><br>Гадаадын хөрөнгө оруулалтыг татах үндсэн нөхцөл бүрдэх Б.Бадрал | “Үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулах судалгаа”-ны ажлын даалгаварт 3 улсын хил дамнасан олон улсын авто замын транзит тээвэрлэлтийн тодорхой хэсгийг Алтанбулаг чөлөөт бүсээр дамжин өнгөрүүлэх асуудлыг тусгасан.<br>Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын ЗГ хоорондын комиссын тээврийн ажлын XIII хуралдааны протоколын төсөлд “Азийн авто замын сүлжээгээр олон улсын тээвэрлэлт гүйцэтгэх тухай” ЗГ хоорондын хэлэлцээрийн хүрээнд энэхүү зорилтыг хэрэгжүүлэх саналыг 2018оны 02 дугаар сарыг 08-ны өдрийн 02/610 тоот албан бичгээр ГХЯ-нд хүргүүлсэн. ОХУ-ын Москва хотноо 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулагдсан Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын ЗГ хоорондын комиссын Тээврийн ажлын хэсгийн XIII хуралдааны үеэр монголын тал “Эдийн засгийн коридор” байгуулах хөтөлбөрийн хүрээнд 3 улсын хил дамнасан олон улсын авто замаар транзит тээвэрлэлтийн тодорхой хэсгийг Алтанбулаг худалдааны чөлөөт бүсээр дамжин өнгөрүүлэх асуудлыг дэвшүүлсэн боловч оросын тал энэхүү асуудал нь тээврийн ажлын хэсгийн хэлэлцэх зүйл бус харин өргөн хүрээ хамарсан хил хамгаалал, гааль болон бусад хяналтын байгууллагуудын оролцоо шаардлагатай тул Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын ЗГ хоорондын комиссын XXII хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалтад тусгаж, хэлэлцүүлэх санал дэвшүүлснийг талууд тохиролцсон. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн XXII хуралдааны протоколын Тээврийн салбарын хамтын ажиллагаа хэсгийн 3.14-т “Монгол Улсын чөлөөт бүс Алтанбулаг болон ОХУ-ын Кяхта хотын хооронд авто замыг нээх саналыг монголын тал дэвшүүлэв” гэж тусгуулсан.<br>Эдийн засгийн коридор хөтөлбөрийн хүрээнд 3 улсын дамжин өнгөрөх тээврийн Алтанбулаг чөлөөт бүсээр дамжин өнгөрөх асуудлыг судлан үзэхэд Оросын талаас Алтанбулаг булаг чөлөөт бүстэй холбогдох гарц байхгүй байна.<br>Эдийн засгийн коридор хөтөлбөрийн хүрээнд 3 улсын дамжин өнгөрөх тээврийн Алтанбулаг чөлөөт бүсээр дамжин өнгөрөх асуудлаар ГХЯ-аас Оросын талд хандсан боловч Оросын талаас уг асуудлыг шийдвэрлэх боломжгүй гэсэн хариу мэдэгдсэн байна. Уг асуудлыг дахин Монгол-Оросын ЗГХК-ын 2018 оны хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар саналаа ГХЯ-д хүргүүлсэн. Гэвч энэхүү асуудал нь Оросын талаас хамаарч байгаа бөгөөд монголын тал бие даан шийдвэрлэх боломжгүй байна.<br>Улаанбаатар хотноо 2019.02 24-25 өдөр Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын Тээврийн ажлын хэсгийн 14 дүгээр хуралдааны протоколын төсөлд Алтанбулаг худалдааны чөлөөт бүсээр дамжин өнгөрүүлэх асуудлыг дэвшүүлсэн боловч оросын тал энэхүү асуудлыг дэмжээгүй болно | 40% |
| 2 | 2.113.1.Хөшигийн хөндийд тээвэр логистикийн төв байгуулах<br><br>Барилгын ажлын гүйцэтгэл хувь 60   | <b>БТГ, АТБХЗГ, ТЗДТБХЗГ, АЗБХЗГ, АТБХЗХ:</b><br>Үндэсний тээвэр логистикийн сүлжээний зураглал гаргах ажлын тайланг хүлээн авсан. Энэ ажлын хүрээнд ХАА-н гаралтай бүтээгдэхүүн, уул уурхай, барилгын салбарын ачаа үүслийн судалгааг хийн уг судалгаан дээр үндэслэн логистикийн төвийн байршлыг тодорхойлон хүлээлгэн өгсөн. Одоо уг судалгааны ажлын хүрээнд ирсэн материалыг нягтлах, дотоодын ачаа урсгалыг тодорхойлох хаанаас хаашаа ямар бараа бүтээгдэхүүнүүд тээвэрлэгдэж байна, гадаад худалдааны бодлого, бусад салбарын баримталж байгаа бодлогоос хамааран ачааны хэмжээнд өөрчлөлт орох эсэх зэрэг судалгааг хийж холбогдох салбарын яамдуудаас санал авах 2019.05.13-ны өдрийн 02/2431 тоот албан бичгийг хүргүүлж санал аваад байна.<br>Мөн Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төсөл, Шинэ нисэх онгоцны буудлыг даган хөгжих шинэ хотын ерөнхий төлөвлөгөөний тодотголд Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийг тусгуулахаар БХБЯ болон Газар зохион байгуулалт, геодизи, зураг зүйн газар, НЕТГ-т санал хүргүүлэн уг төслүүдэд Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийг тусгуулаад байна.<br>Тус яамнаас 2018.09.19-ний өдөр Хөгжлийн банкны төлөөлтэй уулзах уулзалт, Азийн хөгжлийн банкны Эдийн засгийн судалгаа, бүс нутгийн асуудал хариуцсан захирал, төлөөлөгчтэй уулзсан уулзалтад уг төслийн талаар танилцуулан санал  | 40% |



|   |   |   |     |
|---|---|---|-----|
|   |   | <p>тавиад байна.</p> <p>Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийн танилцуулгыг бэлдэн Үндэсний хөгжлийн газрын санхүүжилт шаардлагатай төслүүдийн танилцуулга бүхий сайтад тавиулахаар хүргүүлсэн. Мөн БНСУ-ын “Мэдлэг хуваалцах хөтөлбөр”-ийн хүрээнд 2020 онд хэрэгжүүлэх бодлогын зөвөлгөө авах төсөлд оруулахыг хүсч, Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийн ТЭЗҮ боловсруулах төслийн танилцуулгыг 03/4646 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлээд байна.</p> <p>Гол харилцаатай орнуудаас хөрөнгө оруулалтыг татах боломж нөхцлийг судлан БНСУ-ын “Yooshin Engineering Corporation”-ний дэд ерөнхийлөгч Кимтэй 2018.12.03-ны өдөр зохион байгуулсан уулзалт “Хөшигийн хөндийн холимог тээврийн логистикийн төв байгуулах төсөл”-ийг танилцуулсан.</p> <p>Экзим банкны төслийн менежер Minjung PAK-т “Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийн Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах” төслийн талаарх нэмэлт мэдээлэл ирүүлэх тухай хүсэлтийн дагуу мэдээллийг 2019.02.22-ны өдөр цахим шуудангаар хүргүүлсэн.</p> <p>Японы JICA-гийн “Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл”-д уг төслийн санхүүжилтийг шийдвэрлүүлэх санал хүргүүлсэн.</p> <p>ЗГ-ын 2017 оны 277 дугаар тогтоолоор “Богдхан төмөр зам төслийг “Ар богдын төмөр зам” ХХК-иас Концессын зүйлийн жагсаалтын 53<sup>2</sup>-т нэмэлтээр оруулсан байгааг хүчингүй болгох саналыг Үндэсний хөгжлийн газарт 2017.11.14-ний өдрийн 01/4971, 2018.09.07-ны өдрийн 02/4327 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн.</p> <p>АХБ-аас зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх зээл, тусламжийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт 5 жил тутам шинэчлэгддэг бөгөөд “ТА-8935 MON: Богдхан төмөр замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр”, “Хөшигийн хөндийн холимог тээврийн логистикийн төвийн төсөл”-ийг энэхүү жагсаалтад ахин тусган хэрэгжүүлэх саналыг тус банканд уламжлуулахаар ЗТХ-ийн дэд сайдын 2019.05.09-ний өдрийн 02/2386 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.</p> <p><b>Засгийн газрын 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 260 дугаар тогтоолоор Концессын зүйлийн жагсаалтын 53<sup>2</sup> дахь заалт болох “Богдхан төмөр замын төсөл”-ийг хүчингүй болгосон. Азийн хөгжлийн банкнаас Техникийн туслалцааны хүрээнд хэрэгжүүлэх төслийн жагсаалтад 1 жилийн хугацаатай сунгаж ТЭЗҮ боловсруулах тендер зарлагдсан. Богдхан төмөр замын ТЭЗҮ-д логистикийн төвийн тооцоо судалгаа хамаарагдана.</b></p> <p>Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 265 дугаар тушаалаар Зам, тээврийн салбарын урт хугацааны бодлого боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Уг урт хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хүрээнд Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийн төслийг 2020-2045 онд хэрэгжүүлэх төслийн жагсаалтад оруулахаар ҮХГ-ын төсөл хариуцсан ажлын хэсэгт хүргүүлээд байна.</p> |     |
| 3 | <p>2.113.3.Үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулах судалгаа хийх, батлах</p> <p>Төрөөс логистикийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг батлуулах Т.Батцэцэг</p> | <p>Үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулах Зөвлөх үйлчилгээний тендерт шалгарсан “Монголын логистикийн холбоо” ТББ-тай 2017 оны 267 дугаар гэрээг байгуулсан. Тус холбооноос эхлэл, дунд, эцсийн тайлан ирүүлсэн.</p> <p>- Үндэсний тээвэр логистикийн сүлжээ байгуулах судалгааны ажлын хүрээнд гарсан үр дүнгийн талаар ҮХГ болон холбогдох газрууд, эрдэмтэн судлаачдын дунд хэлэлцүүлэг хийсэн.</p> <p>- Тавантолгойн тээвэр логистикийн асуудлаар яамны газрууд, “АТҮТ” ТӨҮГ, “МТЗ” ТӨХК, “УБТЗ” ХНН-ийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулсан.</p> <p>- Дэлхийн банкны дэд бүтцийн төслийн багийн төлөөлөлтэй уулзалт хийсэн. Төслийн багаас 1-1,5 жилд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн талаар судалгаа хийж байгаа бөгөөд тус банкнаас боловсруулан гаргасан ИнфраСАП хэрэгслээр дамжуулан сонгогдсон төсөл дээр боломжит хувилбаруудыг боловсруулан харьцуулж, дүн шинжилгээ хийснээр Монгол Улс хэрэгжүүлэх хамгийн тохиромжтой хувилбарыг сонгоход тусламж үзүүлэх юм. Уулзалтаар Үндэсний тээвэр логистикийн сүлжээний зураглал гаргаж, төрөөс тээвэр логистикийн талаар баримтлах бодлого боловсруулах ажлын талаар танилцуулан уг ажил дээр хамтран ажиллах санал тавьж, төслийн багийн дэмжлэг авч, сайжруулах, аргачлал зөвлөмжийг, авах талаар тохироод байна.</p> <p>- ЗТХ-ийн сайдын 2019.оны 104 дүгээр тушаалаар төрөөс тээвэр логистикийн талаар баримтлах бодлого боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох яам агентлаг, эрдэмтэн судлаачдыг оролцуулан байгуулаад байна.</p> <p>- ХАА-н гаралтай бүтээгдэхүүн, уул уурхай, барилгын салбарын ачаа үүслийн судалгааг хийн уг судалгаан дээр үндэслэн логистикийн төвийн байршлыг тодорхойлсон. Дотоодын ачаа урсгалыг тодорхойлох хаанаас хаашаа ямар бараа бүтээгдэхүүнүүд тээвэрлэгдэж байгаа, гадаад худалдааны бодлого, бусад салбарын баримталж байгаа бодлогоос хамааран ачааны хэмжээнд өөрчлөлт орох эсэхийг тодруулж, ЗТХ-ийн дэд сайдын 2019.05.13-ны өдрийн 02/2431 тоот албан бичгээр холбогдох яамдуудаас санал аваад байна.</p>   | 40% |





|   |   |   |     |
|---|---|---|-----|
|   |   | <p>Логистикийн төв байгуулах судалгаа хийж, зураглалыг боловсруулсан “Монгол логистикийн холбоо” ТББ-ын ирүүлсэн тайланд санал авахаар ҮХГ-т хүргүүлсэн. ҮХГ-аас бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан Засгийн газраар батлуулах нь зүйтэй гэж үзсэн. ЗГ-т танилцуулахаар хамтарч ажиллаж байна.</p> <p>Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 265 дугаар тушаалаар Зам, тээврийн салбарын урт хугацааны бодлого боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчлэн байгуулан Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 104 дүгээр тушаалаар байгуулагдсан Төрөөс тээвэр, логистикийн талаар баримтлах бодлого боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг татан буулгасан. Уг ажлын хэсгийн хүрээнд Зам, тээврийн салбарын урт хугацааны нэгдсэн бодлогыг боловсруулах, тээвэр логистикийн бодлогыг уг бодлогод тусгахаар ажиллаж байна.</p>   |     |
| 4 | <p>3.2.33.6. Зам, тээврийн салбарын эрдэм шинжилгээ, туршилт судалгааны байгууллагатай болох ажлыг эхлүүлэх</p> <p>Эрдэм шинжилгээ судалгааны байгууллагатай болох холбогдох шийдвэр гаргуулах БТГ(СНХ)</p> | <p>БСШУСЯ-ын захиалгаар хэрэгжсэн “Судалгаа хөгжлийн ажлын асуулга зохион байгуулах” судалгааны ажилд хамтран оролцож, төрийн байгууллагууд тухайлбал зам, тээврийн салбарын эрдэм шинжилгээ, туршилт судалгааны ажлын талаар судалгаа хийсэн.</p> <p>Уг судалгаанд үндэслэн дараах эрх зүйн орчинг бүрдүүлж харьяа газар, байгууллагуудын эрдэм шинжилгээ, судалгааны нэгжүүд байгуулах асуудлыг шийдвэрлүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- 2017.05.11-ний өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар батлагдсан Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 9 дүгээр зүйлийн 9.1.6 дахь заалтад буюу Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “авто замын засвар, арчлалт, хамгаалалт, ашиглалтын нэгдсэн зохион байгуулалтаар ханган эрдэм, шинжилгээ судалгааны ажил хийж, замын стандарт, норматив, техник технологийг сайжруулах үүрэг бүхий авто замын судалгаа, шинжилгээний байгууллага ажиллуулах” гэж оруулан эрх зүйн орчинг бий болгосон. Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 11 дүгээр зүйлд “Авто замын судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллага”-тай болох заалтыг тусгаж, УИХ-ын чуулганы 2017.05.11-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан. Уг судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллагын чиг үүргийг “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-т шилжүүлэх шийдвэрийг ЗТХС-ын 2018.05.04-ний өдрийн 90 дүгээр тушаалыг батлуулсан.</li> <li>- Төрийн өмчийн хорооны 2017.01.24-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын бүтэц зохион байгуулалтыг шинэчлэн “Судалгаа, хөгжил, чанар удирдлагын алба”-тай байхаар оруулан батлуулав.</li> <li>- ЗТХС-ийн сайдын зөвлөлийн хуралдааны 2018 оны 25 дугаар тэмдэглэлийн дагуу “ЗТХТ” ТӨҮГ-аас тус төвийн судалгаа, шинжилгээний баазад тулгуурлан салбарын хүрээлэнгийн бүтэц, орон тоо, дүрэм зардлын тооцоо боловсруулан 2019.04.02-ны өдөр, тус яамнаас өгсөн чиглэлийн дагуу төвийн бүтэц, орон тоонд томоохон өөрчлөлт оруулахгүйгээр тус хүрээлэнгийн бүтэц, зардлын тооцоог дахин боловсруулж тус тус ирүүлээд байна. Ирүүлсэн төсөлтэй танилцаад 2019.05.21-ний өдөр ЗТХ-ийн дэд сайд Л.Халтар, БТГ-ын дарга Ж.Сэрээтэр, АЗБХЗГ-ын дарга Д.Доржханд, “ЗТХТ” ТӨҮГ-ын захирал Р.Буд, “АТҮТ” ТӨҮГ-ын -ийн Судалгаа, хөгжил, чанарын удирдлагын төв дарга Н.Зориг нар уулзалт зохион байгуулсан. Уг уулзалтын хүрээнд Зам, тээврийн хөгжлийн төвөөс ирүүлсэн саналыг дэмжиж, хүрээлэнгийн бүтэц, орон тоог холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж, үйл ажиллагааг энэ оны 6 дугаар сард багтаан эхлүүлэх, шаардагдах зардлыг Авто замын норм, нормативын сангаас санхүүжүүлэхээр тус Сангийн Удирдах зөвлөлийн дарга бөгөөд Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Доржхандад тус тус үүрэг өгсөн.</li> </ul> <p>“Зам, тээврийн салбарын эрдэм шинжилгээ, туршилт, судалгааны байгууллага” байгуулах саналыг ЗТХ-ийн сайдын 2019.05.23-ны өдрийн 01/2705 тоот албан бичгээр БСШУСЯ-нд хүргүүлсэн.</p> <p>БСШУСЯ-ны 2019.07.08-ны өдрийн 1а/6349 дугаарт албан тоотоор ирүүлсэн “Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд 2019.07.23-ны өдрийн 01/3947 дугаарт албан тоотоор саналаа дахин хүргүүлсэн болно. Төсвийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан Сангийн яамнаас шинээр хүрээлэн, төв байгуулах асуудлыг дэмжээгүй тул Засгийн газрын 2019 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар зөвхөн ШУА, түүний хүрээлэнгүүдийн асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлэсэн байна. Уг асуудлаар БСШУСЯ-ны холбогдох газар, хэлтэстэй хамтран ажиллаж байгаа</p> | 40% |
| 5 | <p>4.1.3.1.Зам, тээврийн салбарын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох,</p>  | <p><b>БТГ:</b> Зам, тээврийн салбарын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох, хариуцлага, хяналтын тогтолцоог бүрдүүлэх, хүн ам болон хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах судалгаа зорилтын хүрээнд дараахь ажлуудыг хийгээд байна. Үүнд:</p> <p>“Зам тээврийн салбарын норматив, баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох сангийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-д Зам, тээврийн салбарын хог хаягдлын менежментийн талаар судалгаа хийх, норматив боловсруулах</p>   | 0   |

|  |  |  |
|--|--|--|
| <p>хариуцлага, хяналтын тогтолцоог бүрдүүлэх, хүн ам болон хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах судалгаа хийх</p> <p>Зам, тээврийн салбарын хог хаягдлыг ашиглах технологи боловсруулах БТГ(СНХ)</p> | <p>зэрэг ажлыг хийх 35 сая төгрөгийг тусгуулсан. Зөвлөх үйлчилгээний тендерт шалгарсан “Эс Ай Си Эй” ХХК-тай 2017 оны 265 дугаар гэрээ байгуулсан. Гүйцэтгэгч уг судалгааны тайланг Зам, тээврийн салбарын Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2019.01.10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, хүлээн авч шийдвэрлэсэн. Зөвлөхүүдийн боловсруулсан “Хар тугалганы хүхрийн хүчлийн аккумуляторыг цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлагын стандарт”-ын төслийг Автотээврийн стандартчиллын техникийн хорооны 2019 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар дэмжигдсэн.</p> <p>Зам, тээврийн салбарын хог хаягдлын менежментийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр хүрээнд дараахь ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Зам, тээврийн салбарын хог хаягдлын зохистой менежментийн судалгаа хийх, стандарт боловсруулах, ашиглалтаас хасагдсан автомашины хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулах, ашиглалтаас хасагдсан автомашин, мотоциклийн бүртгэлийн болон мэдээллийн сан бий болгох саналыг боловсруулж, ЗГ-ын 2017 оны 98 тогтоолоор батлагдсан “Агаар, орчны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр”-т тусгуулсан.</li> <li>2. Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд зам тээвэр, барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хэрэгжүүлэх бүрэн эрхэд “тээврийн хэрэгслийн болон барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмыг батлах” заалт оруулах санал өгч, УИХ-ын 2017.05.12-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж батлуулсан.</li> <li>3. Автотээврийн салбарын хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор БОАЖЯ, Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ, НЗДТГ, ШУТИС-ийн Механик тээврийн сургууль, “Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо” ТББ зэрэг байгууллагуудтай хамтарсан хэлэлцүүлэг, уулзалтыг 2017 онд 3 удаа, 2018 онд 2 удаа тус тус зохион байгуулсан. Дээрх хэлэлцүүлэг, уулзалтаас гарсан зөвлөмж, саналыг тус яамны санхүүжилт болон олон улсын байгууллагуудтай хамтран хийж байгаа судалгааны ажил, төслүүдэд тусгаж, цаашид хамтран ажиллах нэгдсэн удирдлага, зохион байгуулалтын механизм бий болгохоор шийдвэрлэсэн. Уг ажлын хүрээнд ЗТХЯ, “Монголын Хог Хаягдлыг Дахин Боловсруулах Үндэсний Холбоо” ТББ-тай зам, тээврийн салбарын хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр “Хамтран ажиллах санамж бичиг”-ийг 2018.06.21-ний өдөр байгуулсан.</li> <li>4. Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/45 дугаар захирамжаар тус яаманд Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт 30 га газар олгосон бөгөөд тээврийн хэрэгслийн ашиглалтын явцад үүссэн хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хог хаягдлыг ангилах, дахин ашиглах, боловсруулах үйлдвэрлэлийг байгуулах чиглэлээр Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоотой хамтран Зам тээврийн салбарын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрлэл технологийн “Авто ресайклинг парк”-ийн төслийг хэрэгжүүлэхээр гэрээний төслийг боловсруулан ажиллаж байна. Мөн ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслийн хог хаягдлыг ангилах, дахин ашиглах, боловсруулах үйлдвэрлэлийг байгуулах чиглэлээр “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨААТҮГ болон “Монгол авто ресайкл парк” ХХК-тай хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулахаар ажиллаж байна.</li> <li>5. Нэгдсэн үндэстний үйлдвэрийн хөгжлийн байгууллага(UNIDO)-тай ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслийн талаар судалгаа 2018 онд хийж, цаашид хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох, дэвшилтэт технологи нэвтрүүлэх, чадавхыг сайжруулах техникийн туслалцааны төслийг боловсруулаад байна.</li> <li>6. Тээврийн хэрэгслийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмын төслийг боловсруулаад байна.</li> </ol> |  |
|--|--|--|

2.3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт:

| Улирал | Хяналтанд байх арга хэмжээ   | 2019 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ | Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/ | Биелэлт /Хувиар/ |     |    |    |   | Үнэлэх боломжгүй |
|--------|--|--------------------------------------|---|------------------|-----|----|----|---|------------------|
|        |  |                                      |   | Дундаж хувь      | 100 | 70 | 40 | 0 |                  |
| III    | Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд | 1                                    | 1   | 40               | -   | -  | 1  | - | -                |



|  |  |  |  |  |  |  |  |  |  |
|--|--|--|--|--|--|--|--|--|--|
| Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт |  |  |  |  |  |  |  |  |  |
|--|--|--|--|--|--|--|--|--|--|

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тус газрын хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний 2019 оны 3 дугаар улирлын хэрэгжилтэд 40 хувийн үнэлгээтэй дараах 1 арга хэмжээг хэрэгжилт хангалтгүй гэж үнэллээ. Үүнд:

| № | Арга хэмжээ   | Хэрэгжилт   |     |
|---|---|---|-----|
|   | 8.3.1.Улаанбаатар хот болон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газрыг түшиглэн хөгжих хот, суурин, хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх<br><br>Боловсруулах ерөнхий төлөвлөгөөний тоо | БТГ: Бичигт хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд зам, тээврийн салбарын талаар тусгах саналыг БХБЯ-нд 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 03/2764 тоот албан бичгээр өгсөн. Баруун бүсийн тулгуур төв Завхан аймгийн Улиастай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд зам, тээврийн салбарын нийт 12 арга хэмжээний саналыг 2019-04-23-ны өдрийн 03/1991 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар Алтанбулаг, Замын-Үүд боомтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын хэлэлцүүлэгт оролцон уг боомтуудад холбоотой зам, тээврийн төсөл, хөтөлбөрийн талаар танилцуулга хийсэн. Мөн Ерөнхий төлөвлөгөө боловсруулж байгаа төслийн багынхантай уулзалт зохион байгуулан шаардлагатай мэдээллээр ханган ажилласан.<br>Сүхбаатар аймгийн Бичигт хилийн боомтын ерөнхий төлөвлөгөө боловсруулж байгаатай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн яамнаас хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 03/2764 тоот албан бичгээр БХБЯ-д хүргүүлсэн. Мөн Монгол Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нэмэлтээр тусгуулахаар зам, тээврийн салбарт хэрэгжих төслүүдийн мэдээлэл, Бичигт боомтод логистикийн төв байгуулах саналыг 2019 оны 09 дүгээр сарын 20-ны 04/5008 тоот албан бичгээр Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт хүргүүлээд байна<br>Монгол, Хятадын хилийн боомтын менежментийн хамтын ажиллагааны комиссын хоёрдугаар хуралдааны протоколын хэрэгжилт, гуравдугаар хуралдаанаар хэлэлцэх асуудалд зам, тээврийн салбараас тусгах асуудлыг Гаалийн ерөнхий газарт хүргүүлсэн. Мөн Монгол, Хятадын хилийн боомтын менежментийн хамтын ажиллагааны комиссын гуравдугаар хуралдаан 2019 оны 9 дүгээр сарын 9-10 өдөр зохион байгуулахад зам, тээврийн яамны холбогдох албан хаагчид оролцсон. | 40% |

2.4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

Тус газарт хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр 110 арга хэмжээ хэрэгжүүлэхээр үүрэг болгосон ба гүйцэтгэлийг авч үзвэл 3 дугаар улирлын байдлаар 90.7 хувийн биелэлттэй байна.

| Улирал | Хяналтанд байх арга хэмжээ                   | 2019 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ | Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/ | Биелэлт /Хувиар/ |     |    |    | Хугацаа болоогүй | Хүчингүй болсон |   |
|--------|--|--------------------------------------|---|------------------|-----|----|----|------------------|-----------------|---|
|        |  |                                      |   | Дундаж хувь      | 100 | 70 | 30 |                  |                 | 0 |
| III    | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт | 110                                  | 110   | 90.7             | 67  | 27 | 1  | -                | 15              | - |

3 дугаар улирлын тайлангаар хууль тогтоомж, тогтоол шийдвэрээс тус газрын хэмжээнд 30 хувийн үнэлгээтэй дараах 1 арга хэмжээг хэрэгжилт хангалтгүй гэж үнэллээ. Үүнд:

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Хэрэгжилт | Үнэлгээ |
|---|------------------------|-----------|---------|
|---|------------------------|-----------|---------|



|   |                                  |  |   |     |
|---|----------------------------------|--|---|-----|
| 1 | ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨМЖ | <p>"УБ метро" төсөл хэрэгжүүлэх тухай 2013.06.10 №24/15" МУ-ын ЗГ-т зөвлөмж болгох нь: 1.Стратегийн ач холбогдол бүхий "УБ метро" төслийг УИХ-аар батлуулж, төслийн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх</p> | <p>Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар "УБ метро" төслийн бэлтгэл ажлын зураг, төсөв боловсруулах, инженер-геологийн нарийвчилсан судалгаа болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх, төслийн зардлыг нарийвчлан тогтоох зэрэг зөвлөх үйлчилгээний санхүүжилтийг Япон Улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх асуудлыг хэлэлцүүлж дэмжүүлсэн. Уг төслийн ТЭЗҮ-ийг гурван үе шаттайгаар бүрэн хийж дуусгасан. МУ-ын ЗГ-аас ажлыг гүйцэтгэх төсвийг шийдвэрлээгүй тул энэ ажил зогссон.</p> <p>Төслийн эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд "Газар доорх төмөр зам буюу Метро"-ны талаарх заалтыг тусгаад байна. Улаанбаатар хотод метро байгуулах хөрөнгө оруулалт татах асуудлаар Нийслэлийн тээврийн газар болон БНХАУ-ын СТЕК хөрөнгө оруулалтын байгууллагатай хамтарсан уулзалтыг 2018 оны 01 дүгээр сард зохион байгуулсан бөгөөд БНХАУ-ын хөрөнгө оруулалтын компанийн зүгээс гэрээ хэлэлцээрийн хүрээнд хамтран ажиллах санал гаргаад байна. Уг төслийг хэрэгжүүлэх зорилгоор НЗДТГ-ын удирдлагуудтай 2018 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр уулзалт хийсэн.</p> <p>"УБ метро" төсөл хэрэгжүүлэх тухай 2013.06.10 -ны №24/15 тушаалын дагуу төслын явцын болон эцсийн хяналтыг хийж зөвлөмжийг өгч ажилласан. Төсөл бүрэн хийгдэж, төслийн баг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлж, хэлэлцүүлсэн. Төслийг дэмжсэн боловч хэрэгжилтийг хангах санхүүжилт байхгүй гэсэн шийдвэр гарсан. Ажлын хэсгийн тушаалд "Яам төсөлд зөвлөх үйлчилгээ үзүүлнэ" гэж туссан байгаа тул хасуулах саналтай байна.</p> | 30% |
|---|----------------------------------|--|---|-----|

2.5. Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Тус газарт Сайдын тушаалаар өгөгдсөн 54 үүрэг даалгаврын хэрэгжилт 83.6 хувьтай байна.

| Улирал | Хяналтанд байх арга хэмжээ                           | 2019 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ | Биелэлт /Хувиар/ |     |    |    | Хугацаа болоогүй | Хүчингүй болсон |   |
|--------|--|--------------------------------------|------------------|-----|----|----|------------------|-----------------|---|
|        |  |                                      | Дундаж хувь      | 100 | 70 | 30 |                  |                 | 0 |
| III    | Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт | 54                                   | 83.6             | 25  | 20 | 1  | 1                | 2               | 5 |

3 дугаар улирлын тайлангаар Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтэд 30 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээг хэрэгжилт хангалтгүй, 1 арга хэмжээг хэрэгжээгүй гэж үнэллээ. Үүнд:

| №  | Төлөвлөсөн арга хэмжээ, хэрэгжилт   | Хэрэгжилт  | Үнэлгээ |
|----|---|--|---------|
| 1. | Ажлын хэсэг байгуулах тухай 2016.04.26 №103<br>4. Батлагдсан удирдам-жийн дагуу хуулийн төслийг боловсруулж, үр дүнг ЗТЯ-ын зөвлөлд 2016 оны IY улиралд багтаан танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Ю.Өлзийжаргал/-д даалгасугай. /Хоолойн тээврийн тухай хуулийн төсөл | Хоолойн тээврийн хөгжлөөр тэргүүлэгч орнуудын талаар судлан дараах орнуудын хуулийг орчуулан харьцуулан судалсан. Үүнд:<br>•Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнуудын Парламент хоорондын ассамблейн тогтоолоор батлагдсан "Дамжуулах хоолойн тээврийн загвар хууль"<br>•АНУ-ын "Дамжуулах хоолойг шинжлэн шалгах, хамгаалах, хуулийн хэрэгжилт хангуулах болон түүний аюулгүй ажиллагааны тухай хууль"<br>•ОХУ-ын "Үндсэн дамжуулах хоолойн тээврийн тухай хууль"<br>•Украин Улсын "Хоолойн тээврийн тухай хууль"<br>•Беларусь Улсын "Үндсэн дамжуулах хоолойн тээврийн тухай хууль" | 0       |



|    |  |  |     |
|----|--|--|-----|
|    | боловсруулахад бусад орны туршлага судлах, мэргэжлийн холбоод, төрийн байгууллагуудтай хамтран ажиллах, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг/ нбд-Ч.Батбаяр  | Хоолойн тээврийн тухай хууль боловсруулах талаар Зам, тээврийн сайдын зөвлөлөөр хэлэлцүүлэн “Хоолойн тээврийн тухай хууль”-ийн төсөл боловсруулахаар дэмжигдэн Ажлын хэсгийн хүрээнд зохих судалгаа хийж, Герман Улсад зохион байгуулсан “Олон улсын хоолойн тээврийн 11 дэх бага хурал”-д оролцон Монгол Улсад хоолойн тээврийг хөгжүүлэхэд техникийн туслалцаа үзүүлэх хүсэлтийг илэрхийлсэн. Ажлын хэсгийн тушаалыг хүчингүй болгох |     |
| 2. | Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай<br>2019.09.10<br>№288" "1. МУЗГ-ын 100 дугаар тогтоолоор Нийслэлийн бүтэц болон ЗД-ын эрхлэх асуудлын хүрээнд зарим агентлагийн бүтцийг өөрчлөн баталсантай холбогдуулан ""Зам, тээврийн салбарт 2018-2020 онд хамтран ажиллах санамж бичгийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө""-ний биелэлтийг эрчимжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.<br>2. ""Зам, тээврийн салбарт 2018-2020 онд хамтран ажиллах санамж бичгийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө""-ний биелэлтийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг улирал тутамд танилцуулж ажиллахыг ЗТХ дэд сайд /Л.Халтар/, НЗД-ын Хөгжлийн бодлогын асуудал хариуцсан нэгдүгээр орлогч дарга /Ж.Батбаясгалан/-д тус тус үүрэг болгосугай. /нбд Т.Батцэцэг/ | Нийслэлийн Ажлын хэсгийн нарийн бичигт Ажлын хэсгийн тушаал, хэлэлцэх асуудлын төслийг хүргүүлэн Ажлын хэсгийн хуралдуулахаар ажиллаж байна.   | 30% |

2.6. Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Тус газарт Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн 24 үүрэг даалгаврын хэрэгжилт 86.1 хувьтай байна.

| Улирал | Хяналтанд байх арга хэмжээ   | 2019 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ | Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/ | Биелэлт /Хувиар/ |     |    |    | Хугацаа болоогүй | Хүчингүй болсон |   |
|--------|--|--------------------------------------|---|------------------|-----|----|----|------------------|-----------------|---|
|        |  |                                      |   | Дундаж хувь      | 100 | 70 | 30 |                  |                 | 0 |
| III    | Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт | 24                                   | 23  | 86.1             | 15  | 6  | 2  | -                | 1               | - |

3 дугаар улирлын тайлангаар ТНБД-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтэд 30 хувийн хэрэгжилттэй 2 арга хэмжээг хэрэгжилт хангалтгүй гэж үнэллээ. Үүнд:

| № | Төлөвлөсөн арга хэмжээ, хэрэгжилт  | Хэрэгжилт  | Үнэлгээ |
|---|--|--|---------|
| 1 | Үнэлгээний хороо байгуулах тухай<br>2019.07.31<br>№242<br>2019.08.12<br>№255 өөрчлөлт оруулсан<br>2. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд хэрэгжих Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км авто замын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог байгуулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга /Ч.Ренчиндамба/-д, холбогдох материалыг архивын нэгж болгон бүрдүүлж, архивт хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг /Б.Оюундэлгэр/-д тус тус үүрэг болгосугай. | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд хэрэгжих Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км авто замын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2019.09.11-ний өдөр зарласан, 10 дугаар сарын 25-ны өдөр тендер нээнэ. | 30%     |



|   |   |   |     |
|---|---|---|-----|
| 2 | Үнэлгээний хороо байгуулах тухай<br>2019.08.06<br>№251<br>2. Холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга /Ч.Ренчиндамба/-д, холбогдох материалыг архивын нэгж болгон бүрдүүлж, архивт хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг /Б.Ганбагана/-д тус тус үүрэг болгосугай. | Зам барилгын ажлын гүйцэтгчийг сонгон шалгаруулах олон улсын тендерийн баримт бичгийн төслийг боловсруулан АХБ-аас 2019 оны 09 дүгээр сарын 11-ний зөвшөөрөл авсан. Тендерийг 2019 оны 09 сарын 12-ны өдөр зарласан. Тендерийг 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдөр нээнэ. | 30% |
|---|---|---|-----|

2.7. Тус газраас Засгийн газрын хуралдаанд оруулах асуудлын төлөвлөгөөний хэрэгжилт:

ЗТХЯ нь 2019 онд Засгийн газрын хуралдаанаар нийт 26 асуудал хэлэлцүүлэхээр төлөвлөж, саналаа ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.

2019 оны 3 дугаар улирлын төлөвлөгөөнд тус газрын ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тусгагдсан асуудлын тоог авч үзвэл:

| № | Хариуцах газар, хэлтэс | Улирал |    |     |    | Нийт |                  |
|---|------------------------|--------|----|-----|----|------|------------------|
|   |                        | I      | II | III | IV | нийт | Үүнээс толгойлон |
| 1 | БТГ                    | 4      | 9  | 13  | -  | 26   | 0                |

БТГ нь 2019 оны 3 дугаар улирлын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөнд 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 86.2 хувийн хэрэгжилттэй байна.

| Улирал | Хяналтанд байх арга хэмжээ   | 2019 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ | Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/ | Биелэлт /Хувиар/ |              |    |    |   | Хугацаа болоогүй |
|--------|--|--------------------------------------|---|------------------|--------------|----|----|---|------------------|
|        |  |                                      |   | Дундаж хувь      | Хэлэлцүүлсэн | 70 | 30 | 0 |                  |
| III    | 2019 оны төлөвлөгөөнд ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тусгагдсан асуудал | 26                                   | 21  | 84.8             | 14           | 5  | 1  | 1 | 5                |

Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тусгагдсан асуудлын хэрэгжилтэд 30 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээг хэрэгжилт хангалтгүй, 1 арга хэмжээг хэрэгжээгүй гэж үнэллээ. Үүнд:

| № | Төлөвлөсөн арга хэмжээ  | Хэрэгжилт  | Үнэлгээ |
|---|---|--|---------|
| 1 | “Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр”-т нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2019-09-25  | Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцийн Хавсралт 17 “Аюулгүй байдал”-д оруулсан нэмэлт, өөрчлөлтийн орчуулгыг хянуулах, баталгаажуулах, “Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр”-т оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг ИНЕГ-ын хэмжээнд бэлтгэх шатанд байна. | 0       |
| 2 | “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл /орон нутгийн хуваарьт нислэгийн болон орон нутгийн нисэх буудлын үйлчилгээ/ | Хуулийн төслийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулан, батлуулахаар ажиллаж байна. ЗТХЯ-ны 2019.09.12-ны өдрийн 09/4825 тоотор ИНЕГ-ыг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн   | 30%     |



|  |  |  |  |
|--|--|--|--|
|  |  | Засгийн газрын 2016 оны “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу дахин боловсруулж ирүүлэхийг мэдэгдсэн. |  |
|--|--|--|--|

2.8. Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт:

БТГ нь 2019 оны 3 дугаар улирлын байдлаар ил тод байдлын шалгуур үзүүлэлт 88 хувийн хэрэгжилттэй байна.

| Улирал | Хяналтанд байх арга хэмжээ      | Хэрэгжүүлэх заалтын тоо | Дундаж хувь | Биелэлт /Хувиар/ |    |    |   | Хугацаа болоогүй |
|--------|---------------------------------|-------------------------|-------------|------------------|----|----|---|------------------|
|        |                                 |                         |             | 100              | 70 | 30 | 0 |                  |
| III    | Ил тод байдлын шалгуур үзүүлэлт | 6                       | 88          | 3                | 2  | -  | - | 1                |

2.9. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллийн нэгдсэн тайлан

БТГ нь 2019 оны 3 дугаар улирлын байдлаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 17 мэдээлэл байршуулах ба гүйцэтгэлийг авч үзвэл 85.9 хувийн хэрэгжилттэй байна.

| Улирал | Хяналтанд байх арга хэмжээ   | 2019 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ | Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/ | Биелэлт /Хувиар/ |     |    |    | Хасагдсан |   |
|--------|--|--------------------------------------|---|------------------|-----|----|----|-----------|---|
|        |  |                                      |   | Дундаж хувь      | 100 | 70 | 30 |           | 0 |
| III    | Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллийн нэгдсэн тайлан | 17                                   | 17  | 85.9             | 9   | 8  | -  | -         | - |

2.10. Тус газраас Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний хэрэгжилт:

БТГ нь 2019 онд Сайдын зөвлөлийн хуралдаанаар толгойлон хэрэгжүүлэх 2, бусад газруудтай хамтран хэрэгжүүлэх 2, нийт 4 асуудал хэлэлцүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнээс 3 арга хэмжээ 100 хувь, Сайдын зөвлөлийн хуралдаанд оруулахаар хүлээгдэж байгаа 1 арга хэмжээ 70 хувийн хэрэгжилттэй байна.

| Улирал | Хяналтанд байх арга хэмжээ                        | 2019 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ | Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/ | Биелэлт /Хувиар/ |      |    |    | Хугацаа болоогүй |   |
|--------|---|--------------------------------------|---|------------------|------|----|----|------------------|---|
|        |   |                                      |   | Дундаж хувь      | 100% | 70 | 30 |                  | 0 |
| III    | Сайдын зөвлөлийн хуралдааны төлөвлөгөөний биелэлт | 4                                    | 4   | 92.5             | 3    | 1  | -  | -                | - |

2.11. Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрийн хэрэгжилт:

Сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрээр БТГ-т нийт 13 үүрэг өгөгдсөн ба гүйцэтгэлийг авч үзвэл 79.2 хувийн хэрэгжилттэй байна.

| Улирал | Хяналтанд байх арга хэмжээ                     | 2019 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ | Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/ | Биелэлт /Хувиар/ |      |    |    |   | Хугацаа болоогүй |
|--------|--|--------------------------------------|---|------------------|------|----|----|---|------------------|
|        |  |                                      |   | Дундаж хувь      | 100% | 70 | 30 | 0 |                  |
| III    | Сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрийн биелэлт | 13                                   | 13  | 79.2             | 4    | 9  | -  | - | -                |

2.12. Зам, тээврийн хөгжлийн сайд, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нар зам, тээврийн салбарт 2018-2020 онд хамтран ажиллахаар байгуулсан “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт:

БТГ нь 2019 онд Зам, тээврийн хөгжлийн сайд, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нар зам, тээврийн салбарт 2018-2020 онд хамтран ажиллахаар байгуулсан “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба гүйцэтгэлийг авч үзвэл 83.8 хувийн хэрэгжилттэй байна.

| Улирал | Хяналтанд байх арга хэмжээ                                | 2019 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ | Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/ | Биелэлт /Хувиар/ |     |    |    |   | Хугацаа болоогүй |
|--------|---|--------------------------------------|---|------------------|-----|----|----|---|------------------|
|        |   |                                      |   | Дундаж хувь      | 100 | 70 | 30 | 0 |                  |
| III    | ЗТХС, нийслэлийн ЗД-тай байгуулсан санамж бичгийн биелэлт | 10                                   | 10  | 83.8             | 5   | 2  | 1  | - | -                |

Зам, тээврийн хөгжлийн сайд, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нар зам, тээврийн салбарт 2018-2020 онд хамтран ажиллахаар байгуулсан “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 30 хувийн үнэлгээтэй дараах 1 арга хэмжээг хэрэгжилт хангалтгүй гэж үнэллээ. Үүнд:

| № | Шалгуур үзүүлэлт   | Хэрэгжилт  | Үнэлгээ |
|---|--|--|---------|
| 1 | Хөшигийн хөндийн “Улаанбаатар” логистикийн төвийн газрыг Шинэ хотын ерөнхий төлөвлөгөөнд оруулах, Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийн барилгын ажлыг эхлүүлэх | БТГ: Богдхан төмөр зам, Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төв байгуулахаар АХБ-тай Зам, тээврийн яам /хуучин нэрээр/ 2014 оны 10 дугаар сард санамж бичиг байгуулсан. Богдхан төмөр зам, Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийн ТЭЗҮ боловсруулах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор АХБ-ны 2018-2020 онд Монгол Улсад хэрэгжүүлэх үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөнд тусгуулах саналыг 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 04/777 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлээд байна. Логистик төвийн байршлыг шинэ хотын ерөнхий төлөвлөгөөнд тусгуулахаар холбогдох саналыг Барилга хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төсөл, Шинэ нисэх онгоцны буудлыг даган хөгжих шинэ хотын ерөнхий төлөвлөгөөний тодотголд Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийг тусгуулахаар БХБЯ болон Газар зохион байгуулалт, геодизи, зураг зүйн газар, НЕТГ-т санал хүргүүлэн уг төслүүдэд Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийг тусгуулаад байна. БНСУ-ын Засгийн | 30%     |





|  |  |  |  |
|--|--|--|--|
|  | <p>2018 онд Улаанбаатар хотоос баруун аймгууд руу тээвэрлэгдэх ачааны түгээлтийг нэгдсэн зохион байгуулалтад оруулна.</p> <p>2019 онд Түгээлтийн хууль эрх зүйн орчинг бүрдүүлнэ.</p> <p>2020 онд Нэгдсэн түгээлтийн систем бий болно.</p> | <p>газрын буцалтгүй тусламжаар 2020 оноос хэрэгжих төслийн саналд Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийн ТЭЗҮ боловсруулах төслийг тусгуулахаар холбогдох материалыг 2018 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 03/4266 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлээд байна. Мөн Европын хөрөнгө оруулалтын банкны Ази хариуцсан захирлыг Монгол Улсад 2018 оны 09 дүгээр сард ажиллах үеэр төслийг танилцуулаад байна. Үндэсний тээвэр логистикийн сүлжээ байгуулах ажлын даалгавар боловсруулан ЗТХЯ-ны ТНБД-аар 2017 оны 6-р сард ТНБД-аар батлуулсан. Уг ажлын даалгаварт Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийн зарим судалгааны ажлыг хийлгэхээр тусгуулсан. Монголын логистикийн холбооноос Үндэсний тээвэр логистикийн сүлжээ байгуулах судалгааны ажлын эцсийн тайланг ирүүлээд байна. Эцсийн тайлантай танилцан дүгнэлт, санал боловсруулан тайлангийн хэлэлцүүлгийг 2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулсан. Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийн танилцуулгыг бэлдэн Үндэсний хөгжлийн газрын санхүүжилт шаардлагатай төслүүдийн танилцуулга бүхий сайтад тавиулахаар хүргүүлсэн. Мөн БНСУ-ын “Мэдлэг хуваалцах хөтөлбөр”-ийн хүрээнд 2020 онд хэрэгжүүлэх бодлогын зөвлөгөө авах төсөлд Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийн ТЭЗҮ боловсруулах төслийн танилцуулгыг 03/4646 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлээд байна. Мөн Монгол Улсын Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтад танилцуулга хүргүүлээд байна. Богдхан төмөр замын чигийн судалгааг 2017 онд АХБ-ны техникийн туслалцаагаар гүйцэтгэсэн ба уг төмөр замын трасс батлагдсны дараа Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төв байгуулах ажлыг эхлүүлнэ. Жич: Хөшигийн хөндийн “Улаанбаатар” логистикийн төвийн газрыг Шинэ хотын ерөнхий төлөвлөгөөнд оруулах, Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийн барилгын ажлыг эхлүүлэх ажлын хүрэх түвшинг 2018 онд Улаанбаатар хотоос баруун аймгууд руу тээвэрлэгдэх ачааны түгээлтийг нэгдсэн зохион байгуулалтад оруулна, 2019 онд Түгээлтийн хууль эрх зүйн орчинг бүрдүүлнэ, 2020 онд Нэгдсэн түгээлтийн систем бий болно гэсэн нь уг ажлын хүрэх түвшин биш гэж үзэж байна.</p> |  |
|--|--|--|--|

### Гурав. Дүгнэлт

Бодлого, төлөвлөлтийн газрын даргын 2019 оны үйл ажиллагааг гүйцэтгэлийн төлөвлөгөө, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгавар, ЗГ-ын хуралдаанд оруулах асуудлын төлөвлөгөөний хэрэгжилт, ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээлэл, сайдын зөвлөлийн хурлын шийдвэр, нийслэлийн Засаг даргатай байгуулсан санамж бичгийн хэрэгжилт тус бүрээр үнэллээ. Төлөвлөж, үүрэг болгосон нийт 351 арга хэмжээ дунджаар 85.3 хувийн биелэлттэй байна. Хэрэгжилт тооцсон арга хэмжээнүүдийн 192 нь биелж, 105 нь 70 хувьтай, 5 нь 40 хувьтай, 7 нь 30 хувьтай, 7 нь хэрэгжээгүй байгаа хугацаа болоогүй 30, хүчингүй болсон 5 арга хэмжээ байна.

### Дөрөв. Санал, зөвлөмж

ЗТХЯ-ны БТГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөө, үйл ажиллагаанд 2019 оны 3 дугаар улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсний үндсэн дээр дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан “Эдийн засгийн коридор” хөтөлбөрийн хүрээнд 3 улсын хил дамнасан олон улсын авто замын транзит тээвэрлэлтийн тодорхой хэсгийг Алтанбулаг чөлөөт бүсээр дамжин өнгөрүүлэх асуудлыг судлан шийдвэрлүүлэх, Үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулах судалгаа хийх, батлах, Хөшигийн хөндийн тээвэр, логистикийн төв байгуулах зэрэг бодлогын томоохон арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, эхлүүлэх, жилийн эцэст хүрэх түвшинд хүргэх;

2. 30 болон 40 хувийн хэрэгжилттэй, хэрэгжээгүй нийт 19 арга хэмжээ тус бүрийн биелэлтийг ахиулах, газар, хэлтсийн дарга, тухайн хариуцсан мэргэжилтнүүдийн 4 дүгээр улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөө дүгнэх шалгуур үзүүлэлтүүдийн нэг болгож ажиллах;



3. Бодлогын баримт бичгүүдэд туссан хөрөнгийн асуудал шийдэгдээгүй төсөл, арга хэмжээнүүд дээр Сангийн яаманд төсөвт тусгуулах санал хүргүүлэхээс гадна хөрөнгө оруулалтыг шийдэх алхмууд хийх, гадаадын зээл, тусламж, концессоор хэрэгжүүлэх боломжийг судлан хөгжлийн түншүүдэд хандах зэрэг бусад арга замаар хөрөнгө оруулалт шийдэх, эрчимжүүлэх чиглэлээр санаачлагатай ажиллах, санал боловсруулж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;

4. Хэрэгжилт хангалтгүй байгаа хөрөнгө оруулалт, санхүүжилт шаардагдахгүйгээр шийдвэрлэх боломжтой арга хэмжээ, үүрэг даалгаврыг ойрын хугацаанд хэрэгжүүлж дуусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах,

5. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, бусад эх үүсвэр, өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулан ойрын хугацаанд гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, төсөл, арга хэмжээний ажлыг эхлүүлэх;

6. Үйлдвэрлэлийг хөгжүүлэх, түүнд шаардагдах хөрөнгө оруулалтыг татах чиг үүрэг нь Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн үндсэн чиг үүрэгт байхаар анх яамны бүтэц, зохион байгуулалт хийгдсэн ч тус хэлтэс нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн ганц чиглэлээ барьж ажиллаж байгаа нь учир дутагдалтай байгаа тул зам, тээврийн салбарын эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөжийн судалгаа, шинжилгээ хийх, үйлдвэрлэлийн тодорхой чиглэлийг хөгжүүлэх бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүдийн хувилбаруудыг боловсруулах ажилд ач холбогдол өгч, газрын стратеги зорилтод тусгагдсан ажлаа бүрэн хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг тус тус зөвлөж байна.

Танилцсан:

Сайд

Б.Энх-Амгалан

Дэд сайд

Л.Халтар

Төрийн нарийн бичгийн дарга

С.Батболд

Бодлого, төлөвлөлтийн  
газрын дарга

Р.Мэргэн

Хянасан:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод  
аудитын газрын даргын үүргийг түр  
орлон гүйцэтгэгч

М.Энхболд

Боловсруулсан:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод  
аудитын газрын ахлах мэргэжилтэн

Н.Буянт

### БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ДҮНГ ГРАФИКААР ҮЗҮҮЛБЭЛ:

